

“ҮНЭТ ЦААСНЫ ТӨВЛӨРСӨН ХАДГАЛАМЖИЙН  
ТӨВ” ХХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ  
...../М.ЭНХСАЙХАН/

“..... ҮЦК” ХХК- ИЙН  
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ  
...../...../

## МӨНГӨН ХӨРӨНГИЙН ГҮЙЛГЭЭ ХИЙХ ГЭРЭЭ БАЙГУУЛАХ ЕРӨНХИЙ ГЭРЭЭ

20 ... оны ... дугаар

№ .....

Улаанбаатар хот

Энэхүү гэрээг нэг талаас Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 4 дүгээр хороо, Самбуугийн гудамж 16/1 хаягт байрлах 6043275 регистрийн дугаартай “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК /цаашид “ҮЦТХТ” гэх/ түүнийг төлөөлж БҮАХГ-н захирал Б.Батсүрэн нөгөө талаас ..... хаягт байрлах..... регистрийн дугаартай “.....ҮЦК” ХХК /цаашид “ҮЦК” гэх/ түүнийг төлөөлж ..... нар /цаашид хамтад нь “Талууд” гэх/ Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Иргэний хууль, Хувь хүний нууцын тухай хууль, Санхүүгийн зохицуулах хороо /цаашид “Хороо” гэх/-ны дүрэм журам, ҮЦТХТ-ийн журам болон бусад холбогдох хууль тогтоомжийг үндэслэн дараах нөхцөлтэйгөөр харилцан тохиролцож байгуулав. **Нэг. Нийтлэг үндэслэл**

- 1.1. Энэ гэрээгээр ҮЦТХТ-ийн “Мөнгөн хөрөнгийн гүйлгээний журам” /цаашид “журам” гэх/-д заасны дагуу ҮЦТХТд бүртгэлтэй ҮЦК-нь харилцагч болон аж ахуй нэгж, хуулийн этгээдтэй төвлөрсөн хадгаламжийн төвийг ерөнхий гэрээний үндсэн дээр төлөөлөн мөнгөн хөрөнгийн гүйлгээ хийх гэрээ байгуулж, мөнгөн хөрөнгийн гүйлгээ хийх гэрээнд тусгагдсан мэдээллийг цахимаар илгээхтэй холбогдуулан үүсэх харилцаа болон талуудын эрх, үүрэг болон хариуцлагатай холбоотой харилцааг зохицуулахад оршино.
- 1.2. Энэ гэрээгээр зохицуулаагүй бусад харилцааг холбогдох хууль тогтоомж, Монголбанк, Хороо болон ҮЦТХТийн баталсан дүрэм, журмаар зохицуулна.

### Хоёр. ҮЦТХТ-ийн эрх, үүрэг

- 2.1. ҮЦТХТ нь дараах эрхийг эдэлнэ:
  - 2.1.1. Мөнгөн хөрөнгийн гүйлгээ хийх гэрээний бүрдүүлбэрт тавигдах шаардлагыг тодорхойлох;
  - 2.1.2. ҮЦК-нь цахим /API/ хаягаар 2.1.1 -т заасан нөхцөлийн дагуу гэрээ байгуулсан эсэхийг түүвэрчлэн шалгах ;
  - 2.1.3. ҮЦК-иас цахим /API/ хаягаар бүртгэсэн мөнгөн хөрөнгийн гүйлгээ хийх гэрээний эх хувийг шаардлагатай тохиолдолд гаргуулан авах;
  - 2.1.4. ҮЦК-ийг гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг шаардах;
  - 2.1.5. Хууль дүрэм журамд заасан бусад эрх
- 2.2. ҮЦТХТ нь дараах үүргийг хүлээнэ:
  - 2.2.1. ҮЦК-иас цахимаар ирүүлсэн хүсэлтийн дагуу түүний харилцагчийн мөнгөн хөрөнгийн зарлагын гүйлгээг түргэн шуурхай гүйцэтгэх;
  - 2.2.2. ҮЦК-ийн харилцагчийн гүйлгээний талаарх мэдээллийг хуульд зааснаас бусад тохиолдолд гуравдагч этгээдэд задруулахгүй байх, нууцлалыг хадгалах;

### Гурав. ҮЦК-ийн эрх, үүрэг

- 3.1. ҮЦК нь дараах эрхийг эдэлнэ:
  - 3.1.1. ҮЦТХТ-ийг гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг шаардах;
  - 3.1.2. ҮЦТХТ-н төвлөрсөн хадгаламжийн данс дах боломжит үлдэгдэлд үндэслэн мөнгө авах хүсэлтийг илгээх;
- 3.2. ҮЦК нь дараах үүргийг хүлээнэ:
  - 3.2.1. Тухайн харилцагчийн мөнгөн хөрөнгийн гүйлгээ хийх гэрээнд тусгагдсан өөрийн нэрийн банкны данс руу нь төвлөрсөн хадгаламжаас мөнгө авах хүсэлтийг нь хянах, түүний үнэн зөвийг баталгаажуулан ҮЦТХТ-рүү API хаягаар илгээн гүйлгээ хийлгэх;
  - 3.2.2. Харилцагчийг үнэт цаасны зах зээлийн болон мөнгөн хөрөнгийн гүйлгээтэй холбоотой мэдээллээр хангах;
  - 3.2.3. Харилцагчтай байгуулсан гэрээний эх хувийг ҮЦК нь өөрийн архивт хадгална.

3.2.4. Цахимаар байгуулсан гэрээний жагсаалтыг цаасан хэлбэрээр тухайн ажлын 5 хоногийн сүүлийн өдөр буюу баасан гаригт гарын үсэг тамга тэмдгээр баталгаажуулан ҮЦТХТ ХХК-д хүргүүлнэ.

3.2.5. Цахимаар байгуулсан гэрээний жагсаалтыг 3.2.4 т заасны дагуу ирүүлээгүй тохиолдолд цахимаар /API/ гурвалсан гэрээ байгуулах эрхийг хязгаарлана.

3.2.6. ҮЦТХТ-ийн мөрдөн ажиллаж буй хууль журам болон энэхүү гэрээний заалтуудыг хэрэгжүүлж ажиллах ба өөрийн буруутай үйл ажиллагааны улмаас харилцагчид учирсан хохирлыг бүрэн хариуцах.

#### **Дөрөв. Хариуцлага**

4.1 ҮЦК-ны энэхүү гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүйгээс үүсэн гарах хариуцлагыг ҮЦТХТ хариуцахгүй.

4.2 ҮЦК-нь өөрийн харилцагчийн төвлөрсөн хадгаламжийн данснаас мөнгөн хөрөнгийн гүйлгээ хийх гэрээний бүрдэл болон түүний үнэн зөвийг бүрэн хариуцах бөгөөд гэрээний 3.1.2, 3.2.1 дэх заалтыг хэрэгжүүлээгүйн улмаас үүсэх аливаа хариуцлагыг ҮЦТХТ хүлээхгүй.

#### **Тав. Маргаан шийдвэрлэх**

5.1 Гэрээгээр хүлээсэн үүргээ хэрэгжүүлэхтэй холбогдон гарсан маргааныг Талууд харилцан тохиролцоо замаар шийдвэрлэнэ.

5.2 Талууд маргаантай асуудлаар тохиролцоонд хүрч эс чадвал гарсан маргааныг МУ-ын хууль тогтоомжид заасны дагуу шүүхээр шийдвэрлүүлнэ.

#### **Зургаа. Бусад**

6.1 Талууд гэрээний аль нэг талын бичгээр ирүүлсэн хүсэлтийн дагуу харилцан тохиролцсоны үндсэн дээр гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулж болно. Гэрээнд оруулсан нэмэлт, өөрчлөлт нь энэхүү гэрээний нэгэн адил хүчинтэй байх бөгөөд гэрээний салшгүй хэсэг байна.

6.2 Энэхүү гэрээ нь Талууд гарын үсэг зурж, тэмдэг дарснаар хүчин төгөлдөр болох ба гэрээний хугацаа нэг жил байна. Гэрээний хугацаа дуусахад аль нэг талаас гэрээг цуцлах тухай санал гаргаагүй тохиолдол гэрээг дахин жилээр сунгагдсанд тооцно.

6.3 Гэрээг хоёр хувь үйлдэн Талууд тус бүр нэг нэг хувийг хадгална.

#### **ГЭРЭЭ БАЙГУУЛСАН**

##### **ҮЦТХТ-ийг төлөөлөн:**

Бизнесийн Үйл Ажиллагаа, Хөгжлийн Газрын  
Захирал: ...../ Б.Батсүрэн /

Хуулийн Зөвлөх: ...../Х.Өсөх/

Хаяг: Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 4 дүгээр  
хороо, Самбуугийн гудамж 16/1

Утас: 7012-0460 И-мэйл: [info@mcsd.mn](mailto:info@mcsd.mn)

##### **.....ҮЦК -ийг төлөөлөн:**

Хаяг: .....

.....

Утас: .....

И-мэйл: .....